

**Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө
оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг,
Засгийн газраас олгосон векселийн үр дүн**

АУДИТЫН ДЭД ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорнод аймгийн Аудитын газар

АГУУЛГА

Агуулга	2
Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	3
Эрсдлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Аудит хийх хугацаа	4
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	4
Тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам	5
Аудитад шаардагдах нөөц	5

Хавсралт №1 Сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл

Хавсралт №2 Аудитын хөтөлбөр

Хавсралт №3 Аудит гүйцэтгэхэд шаарлагатай хөрөнгийн тооцоо,судалгаа

2017.02.14.

Хэрлэн сум

1. Аудитын нэр: Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн.

2. Аудитын код: УАГ-ГАГ/2017/02-ГА, УАГ-ГАГ/2017/04-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын хуулиар тодорхойлсон бүрэн эрх, МУЕА-ын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Үндэсний аудитын газрын харьяа Дорнод аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт: Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын дэд зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх,
- Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх,
- Векселээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй үр, ашигтай хэрэгжсэн эсэх.

5. Хамрах хүрээ: Аудитад аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн алба, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ЗДТГ хамрагдана.

6. Үндсэн мэдээлэл: Дорнод аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2016 оны эцсийн байдлаар аймгийн төв, сумдад нийт улсын төсвөөр 1.7 тэрбум, орон нутгийн төсвөөр 1.0 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхээр батлагдсан байна.

7. Эрсдлийн үнэлгээ: Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэлэв.

8. Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох багууллага, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

9. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн акт, бодлогын бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Иргэний хууль,
- Концессын тухай хууль,
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд,
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам",
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам",
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

10. Аудит хийх хугацаа: Аудитын төлөвлөлтийн орон нутаг дахь үе шатны ажлыг 2017 оны 02 дугаар сарын 10-нд эхэлж, 2016 оны 04 дүгээр сарын 14-ний дотор дуусгаж ҮАГ болон холбогдох албан тушаалтнуудад хүргүүлнэ.

11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорнод аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дэлгэрмаа, шинжээч М.Ухаанбилэг, Я.Зориг нар гүйцэтгэнэ.

12. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдэнэ.

Аудитын тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дарга, Тэргүүлэх аудиторовын тушаалаар батлуулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлнэ.

13. Аудитад шаардагдах нөөц:

А. Хүний нөөц: 3 хүн – 117 хүн/өдөр

Б. Зарцуулах шатахуун: 958.9 мян төгрөг

В. Зам хоног: 648.0 мян төгрөг.

Г. Цалин: 6201.0 мянган төгрөг

Нийт зардал: 7807.9 мян төгрөг

Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, видео камер, зургийн аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын дэд төлөвлөгөөг

Хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕРИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Д.НАРМАНДАХ

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР
ШИНЖЭЭЧ



Б.ДЭЛГЭРМАА
М.УХААНБИЛЭГ
Я.ЗОРИГ